



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/304

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас  
балансад шилжүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын балансад бүртгэлтэй 47,100,000.00 (дөчин долоон сая нэг зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэх өртөггүй тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Хот байгуулалт, хөгжлийн газар (Г.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2.Тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэцүүлэн ашиглалтын хугацааг тогтоож, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг “Налайх барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ (С.Батжаргал)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110201462

Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
 ...03-09-ийн... сарын 25... өдрийн  
 ...А/304-8702... захирамжийн  
 хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгуулага	Шилжүүлэн авах байгуулага
1	Бага багтаамжийн автобус	Hyundai. Starex-	03-37 УНУ	KMJWA37 RACU4957 11	2013	47,100,000	47,100,000	00	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар	"Налайх барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн										
						47,100,000	47,100,000	00		